

ЭРДЭНЭ РЕСУРС 2025 ОНЫ ТАЙЛАН, БАЯНХӨНДИЙ АЛТНЫ УУРХАЙ БА ХАЙГУУЛЫН МЭДЭЭЛЛИЙГ ТАНИЛЦУУЛЛАА

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот

2026.03.24

Онцлох мэдээлэл:

- 2025 оны 3-р улиралд өндөр агуулга бүхий Баянхөндий алтны уурхайн бүтээн байгуулалтын ажлыг эцэслэсэн
- 2025 оны 9-р сард анхны алтыг олборлон, 2025 онд нийт 7,434 унц алтыг дунджаар 4,187 ам.доллар/унц ханшаар борлуулж, дагалдах бүтээгдэхүүнтэй (Ag) хамт нийт 31 сая ам.долларын борлуулалтын орлого олсон.
- Зуун Мод молибден-зэсийн порфирийн төслийн хараат бус шинэчилсэн нөөцийн тайланг танилцуулж, урьдчилсан эдийн засгийн тооцооллыг эхлүүлсэн.
- Тэрэг Уул зэс-алтны төсөлд 80% хүртэлх эзэмшил авах опционы гэрээнд гарын үсэг зурсан.
- Баянхөндий (Хар Морь), Зуун Мод (молибден), Хөвийн Хар (зэс), Тэрэг Уул төслүүдэд хайгуулын хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD; MSE:ERDN; OTCQX: ERDCF) ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани") нь 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлан, Монголиан Майнинг Корпорэйшн ("ММС")-тэй хамтран эзэмшдэг Эрдэнэ Монгол ХХК-ийн хөгжүүлж буй Баянхөндий алтны ордын мэдээллийг танилцуулж байгаадаа таатай байна. SEDAR болон компанийн вебсайт дээр байршуулсан 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан ("MD&A" эсвэл "Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ"), жилийн эцсийн мэдээллийн товхимол нь энэхүү хэвлэлийн мэдээний салшгүй хэсэг болно. Өөрөөр мэдээлээгүй бол мөнгөн тэмдэгт нь канад доллараар илэрхийлэгдсэн.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: "Баянхөндий алтны уурхай нь Ази тивийн хамгийн сонирхол татахуйц шинэ эрдсийн бүсүүдийн нэг болох Хөндий Эрдсийн Дүүргийн хөгжүүлэлтийн суурь төсөл юм. ММС-тэй байгуулсан түншлэл болон хэд хэдэн хөгжүүлэлтийн төслүүдийн дэмжлэгтэйгээр бид энэхүү дүүрэгт тэлэх боломжуудыг эрэлхийлэхийн хамт үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулж байгаадаа баяртай байна."

Тэрээр үргэлжлүүлэн, "Баянхөндий алтны уурхайн үйл ажиллагааны эхний саруудын ахиц дэвшилд бид сэтгэл хангалуун байна. Түүнээс гадна, 2027 оны 3-р улирлаас эхлэн Баянхөндий боловсруулах үйлдвэрт боловсруулах өндөр агуулга

бүхий Хар Морь төслийн нөөцийг тэлэх боломжтой хайгуулын үр дүнг танилцууллаа. Бид тусгай зөвшөөрлийн хүрээнд уурхайн ашиглалтын хугацааг уртасгах, үйл ажиллагааг өргөжүүлэх олон боломж байгааг тодорхойлсон.”

“Мөн бид 2025 онд 100% эзэмшлийн төслүүдээ ахиулсан амжилттай байв. 10-р сард Зуун Мод молибден-зэсийн төслийн хараат бус шинэчилсэн нөөцийн тооцооллыг танилцуулж, уг төслийг Азийн хамгийн том хөгжүүлэлт хийгдээгүй төслүүдийн нэг болохыг баталгаажуулсан. Үүнээс гадна, дэлхийн хамгийн том зэс-алтны ордуудын нэг болох Оюу Толгой ордын ойролцоо байрлах талбайд 80% хүртэлх эзэмшил олж авах опционы гэрээг байгуулсан. 2026 оны эхэнд татан төвлөрүүлсэн санхүүжилт нь эдгээр төслүүдийн хөгжүүлэлтийг эрчимжүүлэх боломжийг бүрдүүлж байна.”

2025 оны онцлох үйл явдлууд:



Зураг – цагийн зүүний дагуу: Баянхөндий уурхай, ЭМ олборлолтын баг, Боловсруулах үйлдвэр, ЭМ боловсруулах үйлдвэрийн баг

Баянхөндий алтны уурхай – 50% эзэмшил

- 2025 оны 3-р улиралд Баянхөндийн бүтээн байгуулалтыг эцэслэн, шаардлагатай зөвшөөрлүүдийг авч, улсын комисст хүлээлгэн өгсөн.

- Баянхөндий орд нь жилд 650,000 тонн хүдэр боловсруулж 85,000 унц хүртэл алт олборлох хүчин чадлаар төлөвлөгдсөн бөгөөд 2025 оны 12 дугаар сарын байдлаар боловсруулах үйлдвэр нь нэрлэсэн хүчин чадлынхаа 88%-д хүрсэн.
- Бүтээн байгуулалтын зардал 120 сая ам.доллар буюу төслийн төсвийн 20%-ийн хэлбэлзлийн хүрээнд багтсан.
- 2025 оны 9 сард анхны алтыг олборлосноос хойш 7,434 унц алт, 2,634 унц мөнгө олборлож, борлуулсан.
 - ЭМ нь алтыг 4,187 ам.доллар/унц, мөнгийг 54 ам.доллар/унц жигнэсэн дундаж ханшаар борлуулсан.
- Хар Морь болон Алтан Сум талбайд уурхайн ойролцоо нөөцийг тэлэх боломжийг шалгах зорилгоор 5,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэсэн.
 - Өмнөд Хар Морь талбайд өндөр агуулга бүхий алтны хүдэржилтийг тэлж, газрын гадаргад ойр бүсэд 28.7 г/т алтны агуулга бүхий 3 метр, 9 г/т алтны агуулга бүхий 19 метрийн интервал огтолсон.
 - Хойд Хар Морь талбайд анхдагч хүдэрт шилжих шилжилтийн хэсэгт алтны хүдэржилт бүхий олон бүсийг огтолсон бөгөөд үүнд овоолгон уусгалтад тохиромжтой 1.9 г/т алтны агуулга бүхий 43 метрийн интервал багтаж байна.
 - Алтан Сум талбайд газрын гадаргад ойр интервалууд огтолсонд: газрын гадаргаас 5.6 метр гүнээс эхлэн 16.2 г/т алтны агуулга бүхий 1 метрийг багтаасан 1.4 г/т алтны агуулга бүхий 16 метр интервал, 124 г/т мөнгөний агуулга бүхий 2 метрийн интервалууд багтаж байна.
 - Хойд Хар Морь талбайд овоолгон уусгалтын технологиор боловсруулахад тохиромжтой байх бага агуулга бүхий өргөн бүсүүдийг тодорхойлсон.
- Орон нутгийн хөгжил болон оролцогч талуудын хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн.
 - Жилийн эцсийн байдлаар төслийн талбай дээр ажиллаж буй ажилтнуудын 40 гаруй хувь нь Баянхонгор аймгийн иргэд, Эрдэнэ Монголын нийт ажилтнуудын 14% нь эмэгтэйчүүд байна.
 - Төслийн үйлчилгээ болон байгаль орчны хөтөлбөрүүдийн хүрээнд орон нутгийн гэрээт гүйцэтгэгчидтэй хамтран ажиллаж байна.

Хөндий Эрдсийн Дүүргийн хайгуул, хөгжүүлэлт

- Зуун Мод төслийн шинэчилсэн, хараат бус нөөцийн тооцооллыг боловсруулсан.
 - Молибденийн Баттай болон Бодитой нөөц 22%-аар өсөж 333 сая фунт (“Mlbs”), Боломжтой нөөц 90%-аар өсөж, 300 сая фунт болсон.
 - Зэсийн Баттай болон Бодитой нөөц 16% өсөж, 384 сая фунт (“Mlbs”), Боломжтой нөөц 75% өсөж 350 сая фунт болсон.
 - 2026 оны дундуур урьдчилсан эдийн засгийн тооцооллыг боловсруулахаар төлөвлөсөн.
- 2025 оны эцэст Хөвийн Хар тусгай зөвшөөрлийн талбайд нийт 3,362 метрийн 24 цооног өрөмдсөн.
 - Зуун Мод ордод газрын гадаргаас 150 метр гүн хүртэл 18 цооногийг өрөмдөж, нөөцийн үргэлжлэлийг баталгаажуулан, зарим хэсэгт тэлсэн.

- Зуун Мод ордоос 4 км-т орших Хөвийн Хар зэс-мөнгөний хэтийн төлөв бүхий талбайд 1.25% зэсийн агуулга бүхий 30 метрийн интервал огтолсон.

Компанийн тухай

- Тэрэг Уул зэс-алтны порфирийн илрэл бүхий талбайн 80 хүртэл хувь эзэмших эрхийг олж авах гэрээнд гарын үсэг зурсан.
 - Төслийн талбай нь Оюу Толгой зэсийн ордын трендийн дагуу, баруун урд зүгт 10 орчим км-ийн зайд байрладаг.
 - Хайгуулын болон геофизикийн судалгаагаар 2026 онд өрөмдлөгөөр шалгах алт, зэсийн хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон.
- 2025 оны 9 сарын 2-нд энгийн хувьцааг 6:1 харьцаатай нэгтгэсэн.
 - Хувьцааны нэгтгэлийн үр дүнд нийт гаргасан болон эргэлтэд буй хувьцааны тоо ширхэг 366,351,958-аас 61,063,549 болсон.
- 2026 оны 2 сард хаалттай, тогтоосон үнээр худалдан авах баталгаа гаргасан \$28,747,000 долларын санхүүжилтийг эцэслэсэн.
 - Нэгж бүр нь \$8.90 долларын үнэлгээ бүхий 3,230,000 ширхэг энгийн хувьцааг нэмж гаргасан.
- 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон тайлант жилийн хугацаанд \$8,181,842-ын цэвэр алдагдалтай байсан ба 2024 оны 12 сарын 31-нд \$8,245,886 цэвэр алдагдалтай байв.
 - 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хайгуул, үнэлгээний зардал 2,448,232 доллар байсан нь 2024 оны 1,852,642 доллараас өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлт нь 2025 оны 7 сард опцион гэрээгээр авсан Тэрэг Уул төслийн хүрээнд гарсан зардал болон шинэ төслүүдийн үнэлгээний ажлыг нэмэгдүүлсэнтэй голчлон холбоотой.
 - 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн хугацаанд компанийн ерөнхий болон захиргааны зардал 3,997,960 доллар байсан нь 2024 оны 5,043,058 доллараас буурсан үзүүлэлт юм. Энэхүү бууралтын үндсэн шалтгаан нь төслийн санхүүжилттэй холбоотой нэг удаагийн зардал болон Стратегийн түншлэлийг эцэслэсэнтэй холбоотой өнгөрсөн оны зардлууд байсанбөгөөд үүнийг тайлант онд хэрэгжсэн амьжиргааны өртгийн өсөлтийн нөлөө хэсэгчлэн сааруулсан байна.
 - Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаас хүлээсэн алдагдал нь 2025 оны 3 болон 4-р улиралд алтны борлуулалтаас үүдсэн цэвэр мөнгөн орлогын нөлөөгөөр буурч, 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд 1,917,471 доллар болсон нь 2024 оны 3,245,109 ам.доллараас буурсан үзүүлэлт юм. Гэвч Баянхөндий уурхайн бүтээн байгуулалт дууссаны дараа зээлийн хүүгийн зардал нэмэгдсэн нь уг эерэг нөлөөг хэсэгчлэн сааруулсан.

Жилийн эцсийн тайлангийн хурал

Компанийн удирдлага 2026 оны 3 сарын 25-ны өдрийн өглөөний 9:00 цагт (Зүүн эргийн цаг, EST) вебкаст зохион байгуулж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай холбоотой мэдээллийг танилцуулна. Оролцохыг хүсвэл дараах холбоосоор бүртгүүлнэ үү: [ВЕБКАСТ](#)

Вебкастын бичлэгийг уг холбоосоор нэг жилийн хугацаанд үзэх боломжтой. Утсаар холбогдон оролцох бол:

- Хойд Америк – төлбөргүй дугаар: (+1) 800 717 1738
- Олон улсын дугаар: (+1) 289 514 5100

Мэргэшсэн этгээд

Компанийн Өсөлт хөгжил хариуцсан захирал Жон Лёнс (FAusIMM) нь Ашигт малтмалын төслийн мэдээлэл тайлагналын стандарт (NI 43-101)-д заасан “Мэргэшсэн этгээд” бөгөөд хэвлэлийн мэдээнд багтсан Баянхөндий уурхайн үйл ажиллагааны мэдээллийг компанийн өмнөөс хянан, баталгаажуулсан болно.

Компанийн ахлах геологич Петер Далтон (Нова Скошиа муж) нь Ашигт малтмалын төслийн мэдээлэл тайлагналын стандарт (NI 43-101)-д заасан “Мэргэшсэн этгээд” бөгөөд хэвлэлийн мэдээнд багтсан хайгуул, техникийн мэдээллийг компанийн өмнөөс хянан, баталгаажуулсан болно.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Баянхөндий алтны уурхайн олборлолтоос гадна Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Хөндий Эрдсийн Дүүрэгт Баянхөндий алтны төслийн орчимд хэд хэдэн үнэт болон суурь металлын төслүүдийн хувь эзэмшдэг. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто (TSX:ERD) болон Монголын хөрөнгийн биржүүд (MSE:ERDN) ба OTCQX зах зээлд (OTCQX:ERDCF) бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com-оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн

хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн эх хувилбараас орчуулагдсан болно. Англи, монгол хувилбарын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>